

ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ДАГУУ АЖИЛЛАХГҮЙ БАЙГААД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Батцэнгэлийн Мөнхжаргал, МУИС-ШУС-ийн Эдийн засгийн тэнхим, ахлах багш, докторант

Хураангуй

Судалгааны зорилго нь ажил эрхэлж байгаа их дээд сургууль (ИДС) болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага (МБСБ) төгсөгчдийн мэргэжлээсээ өөр чиглэлээр ажил эрхлэх байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах явдал юм. Судалгаанд Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ)-ийн “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2017 (2015-2016 оны төгсөгчид)” судалгааны 44.9 мянган төгсөгчдийн мэдээллийн баазыг хоёрдогчоор ашигласан ба binary logistic regression аргаар шинжилгээ хийсэн. Судалгаагаар, 2015-2016 оны хичээлийн жилд мэргэжил эзэмшүүлэх сургуулиа төгссөн, мэдээлэл цуглуулах үед ажил эрхэлж байсан төгсөгчдийн мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллах байдал ИДС төгсөгчдийн дунд 30.2%, МБСБ төгсөгчдийн дунд 38.8% байна. Тэдний мэргэжилтэйгээ тохирохгүй ажил хийх байдалд хувь хүний шинж чанарууд; мэргэжил эзэмшсэн түүх, байдал; ажил хөдөлмөрт бэлтгэх чиглэлээр гаргасан хувь хүний нэмэлт хүчин зүтгэл, оролдлогууд болон ажиллах эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажлын байр/ажил олгогчдын онцлог, олгох цалин, сурсан мэдлэг чадварынх нь ажлын байран дээр хэрэг болох байдал зэрэг багц үзүүлэлтүүд статистик ач холбогдолтойгоор нөлөөтэй гэж гарсан. Энэ удаагийн шинжилгээний үр дүнг ХНХСИ-ийн “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа 2017”-ийн үр дүнтэй холбон үзвэл, 2018 оны хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн нөхцөл байдал нь МБСБ төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэлтийг бууруулахад илүү эерэг нөлөө үзүүлэх боломжтой, харин ИДС төгсөгчдийн хувьд дорвитой нөлөө үзүүлэхгүй байх хандлагатай байна.

Түлхүүр үгс: ИДС, МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт; мэргэжлийн дагуу ажиллахгүй байх; мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэх; мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэлтийн шалтгаан; мэргэжлийн дагуу ажиллахгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс

Abstract

The research aims to study the determinants of “mismatched employment” (employment in jobs that are not fitting for profession or major) among Mongolian graduates from tertiary educational institutes/universities (IU) and Technical and vocational education and training (TVET). The 44.9 thousand graduates' database of survey on “Graduates' employment status-2017 (2015-2016 graduates)”, conducted by the Research Institute for Labor and Social Protection (RILSP) has served as the secondary database for this study and binary logistic regression method was used for the analysis. According to the study, 30.2% of employed IU graduates and 38.8% of employed TVET graduates tend to work in jobs that are different from their major. The main determinants that are statistically significant for mismatched employment of graduates include their individual characteristics; qualification background and status; additional individual effort and commitment for career development; economic sectors for employment; employers/workplace features; salary and necessity of their competence on work place and so on. When connecting the results of this study with the “Barometer survey on labor market demand -2017” of RILSP, a 2018 situation of labor market demand is likely to be more favorable for decreasing the mismatched employment of TVET graduates but is effectless for that of IU graduates.

Key words: employment of graduates from IU, TVET; mismatched employment; employment in jobs that are not fitting for profession/major; determinants of mismatched employment;

1. ОРШИЛ

Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд хөлөө олох, үр бүтээлтэй ажиллахтай холбоотой олон бэрхшээл, тулгамдсан асуудлууд өнөөгийн Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд дээр байгаа билээ. Тухайлбал, төгсөгчид

мэргэжлийн дагуу ажил олж эрхэлж чадаж байгаа эсэх, сонгон эрхэлж байгаа ажил нь эзэмшсэн боловсрол ур чадварын түвшинд нь тохирч байгаа эсэх, мөн ажилд орсны дараа сургуульд эзэмшсэн мэдлэг, чадвар нь ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх гээд олон асуудлууд нь төгсөгчид төдийгүй хүн амын боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан бодлого хөтөлбөр боловсруулагчид, төлөвлөгчид,

үнэлээчдийн анхаарлын төвд байдаг.

МУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт¹⁰-ээс бэлтгэсэн “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2017 (2015-2016 оны төгсөгчид)” тайлангаар¹¹, 2015-2016 оны хичээлийн жилд сургуулиа төгссөн нийт ИДС/МБСБ төгсөгчдийн 60.9 хувь буюу 27391 нь 2017 оны сүүлийн хагасын байдлаар ажил эрхэлж байсан. Гэвч тэдгээр ажил эрхэлж буй төгсөгчдийн дунд эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхэлж байгаа байдал буюу мэргэжлийн дагуу биш ажил эрхлэх байдал их/дээд сургууль (ИДС) төгсөгчдийн хувьд 30.2 хувь, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага (МБСБ) төгсөгчдийн хувьд 38.8 хувь байна. Мөн олон улсад хэрэглэгддэг ажил мэргэжлийн ангилал болох YAMAT ангиллаар төгсөгчдийн эзэмшсэн мэргэжил болон одоогийн ажлын байрны ажил мэргэжлийг харьцуулж үзэхэд, ажил эрхэлж байгаа ИДС төгсөгчдийн 38.4 хувь, МБСБ төгсөгчдийн 30.2 хувь нь эзэмшсэн мэргэжлээс доогуур түвшний ажил мэргэжлийн албан тушаал дээр ажил эрхэлж байна. Эдгээр тоо баримтууд нь нэг талаас өөрсдийн сонирхол, боломжид нийцүүлэн мэргэжлээ сонгож суралцан бэлтгэгдсэн боловсон хүчнүүдийн нөөц боломж эдийн засагт бүрэн ашиглагдахгүй байгааг, нөгөө талаас мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлого хөдөлмөрийн зах зээл дэх ажил мэргэжлийн эрэлттэй хангалттай түвшинд уялдаж чадахгүй байгааг харуулж байна.

Дээрх үр дүнгүүдээс гадна судалгаагаар ажил эрхэлж байгаа ИДС төгсөгчдийн 18.8 хувь, МБСБ төгсөгчдийн 23.8 хувь нь өөрийн сургуульд суралцах хугацаанд эзэмшсэн боловсрол, урчадварын түвшинг тухайнажлын байрны шаардлагаасаа доогуур гэж үнэлсэн байна. Ийнхүү ажилтан ажил олгогчийн шаардлагад тэнцэхгүй байдал ажлын байранд байгаа нь хувь хүний хүчин зүйлстэй холбоотой байж болох хэдий ч мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын боловсон хүчин бэлтгэх байдлын чанарыг харуулах өөр нэг хэмжүүр байж болох талтай.

¹⁰ Энэхүү шинжилгээг хийх боломжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт болон Европын холбооны SECiM төслийн хамт олон олгосон бөгөөд мэдээллийн санг ашиглах зөвшөөрөл өгсөнд судлаачийн зүгээс талархал илэрхийлж байна.

¹¹ Түүврийн хэмжээ нь 2015/2016 онд МУ-ын ИДС болон МБСБ төгссөн 4909 төгсөгчид байсан ба тархаалт хийгдсэн мэдээллийн баазыг ашигласан.

МУ-ын хэмжээнд дээрх асуудлууд байсаар ирснийг олон талын оролцогчид ярьсаар ирсэн ч учир шалтгааныг нарийвчлан судалсан судалгаа, тайлбарууд тэр бүр байхгүй байгаа тул энэхүү шинжилгээний ажлаар төгсөгчдийн ажил эрхлэлтэд тохиолдож буй дээрх бэрхшээл, тулгамдсан асуудлуудын нэг болох мэргэжлээсээ өөр чиглэлээр ажил эрхлэх үзэгдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг боломжит мэдээллийн хүрээнд гүнзгийрүүлэн судлахаар зорьлоо.

2. ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Энэхүү шинжилгээний гол зорилго нь ИДС/МБСБ төгссөнөөс хойш 1 жилийн дараах байдлаар ажил эрхэлж байгаа төгсөгчдийн дундах мэргэжлийн дагуу ажиллахгүй байдал, түүнд нөлөөлөх микро түвшний хүчин зүйлсийг судлах явдал юм.

Уг шинжилгээг хийснээр Монгол улс дахь мэргэжилтэй ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн зохицол, нийцлийн тал дээр тулгамдаж буй зарим асуудлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт хийх боломжтой болох ба түүнд үндэслэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх боловсролын салбар болон хөдөлмөрийн салбарын мэргэжилтнүүд зохих бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

3. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР БА СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Мэдээллийн эх үүсвэр

Судалгаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2017 (2015-2016 оны төгсөгчид)” түүвэр судалгааны мэдээллийн баазыг ашигласан. Уг судалгаа нь МУ-д 2013 оноос 2010-2011 оны төгсөгчдийг хамруулан анхлан судлагдаж эхэлсэн ба мөшгөх судалгааны арга, аргачлалын дагуу зохион байгуулагддаг, үндэсний хэмжээнд төлөөлөх чадвар бүхий түүвэр судалгаа юм. 2017 оны судалгаа нь шинээр эхэлж буй мөшгөх судалгааны 1-р үеийн судалгаа ба 2015-2016 оны хичээлийн жилд Монгол улс

дахь ИДС юм уу МБСБ төгссөн 4909 төгсөгчид (мэдээлэл нь 44971 төгсөгчид рүү тархаалт хийгдсэн)-өөс мэдээлэл цуглуулсан байна.

Энэхүү шинжилгээнд 2015-2016 оны хичээлийн жилд төгссөнөөс хойш судалгааны мэдээлэл цуглуулах үед буюу 2017 оны сүүлийн хагаст ажил эрхэлж байсан 27391 (тархаалт хийгээгүйгээр 2907) төгсөгчдийн мэдээллийг ялган авч шинжилсэн. Эдгээр төгсөгчдийн 18913 нь ИДС төгссөн ажиллаж буй хүмүүс, 8478 нь МБСБ төгссөн ажиллаж байгаа хүмүүс байсан.

Судлаачийн хувьд мэдээллийн эх үүсвэр нь хоёрдогч эх үүсвэр тул хязгаарлагдмал хувьсагчуудын хүрээнд шинжилгээ хийгдсэн. Тодруулбал, мэргэжлийн дагуу ажиллахгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг макро түвшний үүднээс тайлбарлах боломжгүй байсан.

3.2 Шинжилгээний ойлголт, тодорхойлолт ба хүрээ

Шинээр хөдөлмөрийн зах зээлд хөл тавин орж буй төгсөгчдийн мэргэжлийнхээ дагуу биш ажил эрхлэх байдалд нөлөөлөх хүчин

зүйлсийг ИДС төгсөгчид болон МБСБ төгсөгчдийн хувьд тусад нь судалсан.

Шинжилгээний гол хамаарах хувьсагч болох Мэргэжлийн дагуу ажиллаж байгаа эсэх-ийг хэмжихдээ “Эрхэлж буй ажил тань эзэмшсэн мэргэжилтэй чинь хэр тохирч байна вэ?” гэсэн асуултад ажил эрхэлж буй төгсөгч “огт тохиромжгүй” эсвэл “тийм ч тохиромжтой биш” гэж хариулсан бол “мэргэжлийн дагуу бус/эзэмшсэн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхэлж байгаа”, харин “тохиромжтой” эсвэл “маш тохиромжтой” гэж хариулсан бол “мэргэжлийн дагуу ажиллаж байгаа” гэж үзсэн.

Мэргэжлийн бус ажил эрхлэлтийн түвшин-г тооцоходоо мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхэлж байгаа төгсөгчдийн тоог нийт ажил эрхэлж буй төгсөгчдийн тоонд харьцуулан хувиар хэмжсэн.

Дээрх үзэгдэлд нөлөөлж болох хүчин зүйлс буюу тайлбарлах хувьсагчдыг ерөнхийд нь 5 бүлэгт ангилан судалсан ба тэдгээрийн ерөнхий жагсаалтыг Зураг 1-д, дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 1-д тус тус харуулав.

Зураг 1: Дүн шинжилгээний хүрээ



3.3 Шинжилгээний арга


Тайлбарлагч хүчин зүйлүүд мэргэжлийн дагуу ажиллахгүй байдалд хэрхэн нөлөөлж буйг судлахдаа, олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний “binary logistic regression” аргыг ашигласан. Уг регрессийн шинжилгээ нь У-ыг таамаглахдаа үзэгдлийн илрэх эсвэл илрэхгүй тохиолдлын магадлалыг сонирхдог ба судлагдаж байгаа хамаарах хувьсагч (У) нь хуурмаг хувьсагч байх үед тохиромжтой байдаг.

Ложистик регрессийн шинжилгээ нь судалж буй үзэгдлийн илрэх магадлал¹²-ыг тайлбарлагч хувьсагчдын бүлэг тус бүрийн хувьд, гэхдээ аль нэг бүлгийг суурь болгон, бусдыг нь түүнд харьцуулсан байдлаар хэмжиж гаргадаг. Тэрхүү хэмжүүрийг судлаачид Odds Ratio (OR) гэж нэрлэдэг ба цаашид энэхүү шинжилгээнд OR үзүүлэлтийг би “харьцангуй магадлал” гэж нэрлэсэн болно. Х-ийн суурь бүлгийн хувьд OR нь “1.000” гэсэн утга авах ба бусад бүлгүүдийн хувьд тооцогдсон OR нь сонирхож буй үзэгдэл илрэх магадлал (Odds-оор хэмжигдсэн) суурь бүлэгтэй харьцуулахад бусад бүлгийнхний хувьд хэд дахин их/бага байгааг харуулна.


4. ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Мэргэжил эзэмшүүлэх урт хугацааны сургалтууд буюу ИДС, МБСБ-ыг төгссөнөөс хойш 1-1.5 жилийн дараах байдлаар ажил эрхэлж байгаа төгсөгчдийн хувьд мэргэжилтэйгээ тохирох ажил эрхэлж байгаа эсэхийг судалсан үр дүнг Зураг 4.1а, Зураг 4.1б-д харуулав.

Зураг 4.1а. Ажил эрхэлж буй ИДС ТӨГСӨГЧДИЙН хувийн жин, ажил нь эзэмшсэн мэргэжилтэй тохирдог эсэхээр



Зураг 4.1б. Ажил эрхэлж буй МБСБ ТӨГСӨГЧДИЙН хувийн жин, ажил нь эзэмшсэн мэргэжилтэй тохирдог эсэхээр



Төгсөгчдийн эрхэлж байгаа ажил нь тэдний эзэмшсэн мэргэжилтэй хэр нийцэж байгаа талаарх үр дүн ИДС төгсөгч болон МБСБ төгсөгчдийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p \leq 0.001$). Мэргэжилтэйгээ тохирох ажил эрхэлж байгаа байдал ИДС төгсөн ажиллаж буй хүмүүсийн дунд 69.8 хувь, МБСБ төгсөн ажиллаж буй төгсөгчдийн дунд 61.2 хувь байгаагаас харвал ерөнхийдөөнийт төгсөгчдийн дунд мэргэжлийн дагуу ажиллах байдал мэргэжлийн бус ажил хийх хандлагаас илүү байна ($p = 0.000$). Гэхдээ мэргэжлийн бус, ялангуяа мэргэжилтэйгээ огт тохирохгүй өөр чиглэлийн ажил хийх байдал МБСБ төгсөн ажиллаж буй 4 төгсөгч бүрийн 1-д, ИДС төгсөн ажиллаж буй 6-7 төгсөгч бүрийн 1-д тохиолдож байгаа нь анхаарахгүй орхиж болохгүй үзүүлэлт юм.

Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэх байдалд сонгосон тайлбарлах хувьсагчид хэрхэн нөлөө үзүүлж байгааг судалсан ложистик регрессийн шинжилгээний үр дүнг Загвар 1-А хүснэгтэд үзүүлэв. Уг загварын тайлбарлах чадвар статистик ач холбогдол бүхий түвшинд, 79.2-81.3 хувь (ИДС төгсөгчдийн загварт 79.2 хувь, МБСБ төгсөгчдийн загварт 81.3 хувь) гарсан нь загварт сонгон судалсан хүчин зүйлүүд хамтдаа төгсөгчдийн эзэмшсэн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх байдлын шалтгааныг нэлээд өндөр хувьтайгаар тайлбарлаж чадахыг харуулж байна.

Ажил эрхэлж буй төгсөгчдийн мэргэжлийн дагуу ажиллахгүй байдалд тэдний хүйс

¹² Odds гэсэн хэмжүүрээр хэмжигдэх ба энэ нь У хувьсагчийн сонирхоогүй үзэгдлийн 1 тохиолдол бүрийн ард сонирхож буй үзэгдлийн хэдэн тохиолдол байж болох магадлалыг илэрхийлдэг.

болон нас хэрхэн нөлөөлж байгааг авч үзвэл, ИДС төгсөгчдийн хувьд нас, хүйсийн аль нь статистик ач холбогдол бүхий нөлөөгүй байгаа боловч МБСБ төгсөгчдийн хувьд нөлөөтэй гарсан байна. Тухайлбал, МБСБ төгссөн эрэгтэй төгсөгчидтэй харьцуулахад эмэгтэй төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил хийх OR магадлал 1.603 дахин өндөр ($p \leq 0.001$) байна. Насаар нь авч үзвэл, МБСБ төгсөгчдийн нас нэг жилээр нэмэгдэх тусам мэргэжлийн бус ажил хийх байдал 0.915 дахин өөрчлөгдөх буюу 8.5 хувь орчмоор багасах магадлалтай ($p \leq 0.001$) байна. Энэ нь төгссөнөөс хойш тодорхой цаг хугацаанд хүлээж байж, мэргэжлийн ажил олдох боломж гардгийг илтгэж байж болох юм.

ИДС болон МБСБ төгсөгчдийн аль алины хувьд гэрлэлтийн байдал нь тэдний мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэхэд нөлөөтэй гэсэн үр дүн гарчээ. Тодруулбал, гэрлээгүй/салсан хүмүүстэй харьцуулахад гэрлэсэн юм уу хамтран амьдрагчтай ажиллагчдын дунд мэргэжлээсээ өөр чиглэлээр ажил хийх OR магадлал өндөр (ИДС төгсөгчдийн хувьд 1.162 дахин, МБСБ төгсөгчдийн хувьд 1.288 дахин) байна ($p \leq 0.001$). Энэ нь ганц биеэрээ амьдрах бус, гэрлэж өөрөөсөө гадна ардаа гэр бүлийн гишүүдийн өмнө үүрэг хариуцлага хүлээдэг болохын хэрээр хүмүүс заавал мэргэжлийн ажил олдохыг хүлээж суух бус, аль олдсон орлого бүхий ажлыг хийх эрэлт хэрэгцээтэй болдогийг харуулж байж болох юм.

Төгсөгчид мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллах байдал тэдний ажиллаж, амьдарч буй бүс нутгаар багагүй ялгаатай гарсан байна. Жишээ нь, нийслэлд амьдарч байгаа төгсөгчидтэй харьцуулахад Монгол улсын баруун бүсэд амьдарч ажиллаж буй ИДС төгсөгчид 1.506 дахин илүү мэргэжлээсээ өөр чиглэлийн ажил эрхлэх магадлалтай байна ($p \leq 0.001$). Харин хангайн бүсэд амьдарч буй ИДС төгсөгчдийн хувьд мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх OR магадлал эсрэгээрээ нийслэлд байгаа үеийн төгсөгчдийнхөөс бага (0.812 дахин ялгаатай буюу 18.8 пунктээр) байгаа ($p \leq 0.001$) нь тухайн орон нутгийн мэргэжилтэй ажиллах хүчний эрэлтэд ажиллахаар очиж буй төгсөгчдийн мэргэжил эзэмшсэн байдал арай сайн нийцэж байгааг харуулж байна.

МБСБ төгсөгчдийн хувьд нийслэлээс өөр аймаг, бүсүүдэд амьдрах нь мэргэжилтэйгээ

тохирох ажил хийхэд давуу тал олгох магадлалтай ($p \leq 0.05$) гэсэн үр дүн гарчээ. Тухайлбал, нийслэлд ажиллаж амьдарч байгаа МБСБ төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх OR магадлал 1.000 гэж үзвэл, бусад бүсүүдэд амьдарч буй төгсөгчдийн хувьд энэ магадлал нь 0.79-0.927 дахин ялгаатай буюу 7.3-21.0 пунктээр доогуур байна.

Төгсөгчдийн боловсролын түүх, мэргэжлээ сонгон эзэмшсэн байдал, мэргэжилдээ сэтгэл ханамжтай байдал зэрэг нь төгссөнийхөө дараа мэргэжлээрээ ажиллах байдалд хэрхэн нөлөөлж буйг авч үзье.

Мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцахаасаа өмнө ямар нэг шинжлэх ухааны чиглэлээр төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуульд сурч байсан эсэх нь МБСБ төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах эсэхэд статистик ач холбогдол бүхий нөлөөгүй байна. Харин төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д сурч байсан ИДС төгсөгчид төрөлжсөн сургалтгүй ЕБС төгссөн хүмүүсээс 1.8 дахин илүүтэйгээр мэргэжлийн бус ажил хийх хандлагатай ($p \leq 0.001$) байна. Энэ нь төгсөгчид өөрийн давуу талаа ашиглан өндөр цалин юм уу бусад боломж ихтэй мэргэжлийн дагуу бус ажлыг мэргэжлийн ажлаасаа илүүд үзэн сонгох боломжтойгоор тайлбарлагдаж болох юм.

ЗАГВАР 1-А: Ажил эрхэлж буй төгсөгчдийн эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн

Нөлөөлөгч хүчин зүйлс	Эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэх харьцангуй магадлал (Odds ratio)	
	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч
<u>ХУВЬ ХҮНИЙ БОЛОН ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС</u>		
Хүйс		
Эрэгтэй	1.000	1.000
Эмэгтэй	0.971	1.603***
Нас	1.008	0.915***
Гэрлэлтийн байдал		
Гэрлээгүй/салсан/тусгаарласан	1.000	1.000
Гэрлэсэн/хамтран амьдрагчтай	1.162***	1.288**
Өрхийн нэг хүнд ногдох орлого	1.000	1.001***
Амьдарч буй бүс нутаг		
Улаанбаатар	1.000***	1.000*
Баруун	1.506***	0.927
Хангайн	0.812**	0.797*
Төвийн	1.097	0.814*
Зүүн	1.179	1.175
<u>МЭРГЭЖИЛ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ, ТҮҮХ</u>		
Төрөлжсөн сургалттай ЕБС төгссөн эсэх		
Үгүй	1.000	1.000
Тийм	1.842***	1.022
Төгссөн ИДС/МБСБ-ийн өмчийн хэлбэр		
Төрийн өмчийн	1.000	1.000
Хувийн өмчийн	1.226***	0.929
Төгссөн сургуулийн байршил		
Улаанбаатар	1.000	1.000
Бусад аймаг	0.960	1.126
Эзэмшсэн мэргэжлээ сонгосон гол шалтгаан		
Өөрийн хүсэл сонирхлоор	1.000***	1.000***
Бусад хүмүүсийн саналыг дагаж	2.086***	0.113
Тухайн мэргэжлийн ирээдүйд олгох боломжийг харгалзан	1.286***	0.740***
Өөр сонголтгүй байсан тул	1.821***	1.436
Эзэмшсэн мэргэжилдээ сэтгэл хангалуун байдал		
Маш хангалуун	1.000***	1.000***
Хангалуун	3.290***	1.503***
Хангалуун бус	6.301***	10.993***
Огт хангалуун бус	2.523***	21.045***
ИДС төгсөгчдийн мэргэжлийн чиглэл		
Багш, боловсрол судлал	1.000***	n/a
Урлаг	0.613*	n/a
Хүмүүнлэгийн ухаан	0.707**	n/a
Нийгэм, эдийн засаг	2.897***	n/a
Мэдээлэл, сэтгүүл зүй	1.852***	n/a
Бизнес, удирдлага	0.847	n/a
Хууль, эрх зүй	2.364***	n/a
Биологи	1.718**	n/a
Физик, хими, геологи, газарзүй	2.062***	n/a
Математик, статистик	1.805	n/a
Компютер	0.986	n/a
Бүх төрлийн инженер	1.606***	n/a

ЗАГВАР 1-А: Ажил эрхэлж буй төгсөгчдийн эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн

Нөлөөлөгч хүчин зүйлс	Эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэх харьцангуй магадлал (Odds ratio)	
	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч
Үйлдвэрлэлийн технологи	1.247*	n/a
Барилга, архитектур	0.850	n/a
ХАА, ой, загасны аж ахуй	1.564***	n/a
Мал эмнэлэг	0.528**	n/a
Анагаах ухаан	0.914	n/a
Нийгмийн халамж, хангамж	1.654 **	n/a
Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	3.852***	n/a
Тээвэр	0.649	n/a
Байгаль хамгаалал	3.762***	n/a
МБСБ төгсөгчдийн мэргэжлийн чиглэл		
Боловсрол	n/a	1.000***
Соёл урлаг	n/a	1.298
Санхүү, бизнес, худалдаа	n/a	0.714
Мэдээллийн технологи	n/a	1.112
Байгаль орчин, аялал жуулчлал	n/a	1.767
Барилга	n/a	1.200
Тээвэр	n/a	0.609
Эрчим хүч	n/a	0.823
Уул уурхай	n/a	0.872
Хөдөө аж ахуй	n/a	0.901
Аж үйлдвэр	n/a	0.470
Үйлчилгээ	n/a	0.662
Эрүүл мэнд	n/a	0.149**
Эзэмшсэн мэргэжлээ сонгосон гол шалтгаан		
Өөрийн хүсэл сонирхлоор	1.000***	1.000***
Бусад хүмүүсийн саналыг дагаж	2.086***	0.113
Тухайн мэргэжлийн ирээдүйд олгох боломжийг харгалзан	1.286***	0.740***
Өөр сонголтгүй байсан тул	1.821***	1.436
Эзэмшсэн мэргэжилдээ сэтгэл хангалуун байдал		
Маш хангалуун	1.000***	1.000***
Хангалуун	3.290***	1.503***
Хангалуун бус	6.301***	10.993***
Огт хангалуун бус	2.523***	21.045***
Давхар/хос мэргэжил эзэмшсэн эсэх		
Тийм	1.000	1.000
Үгүй	1.802***	0.860*
АЖИЛ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАРГАСАН ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ, ОРОЛДЛОГО		
Сургуульд элссэнээс өнөөг хүртэл ажил хөдөлмөртэй холбоотой сургалт/хөтөлбөр/ арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх		
Тийм	1.000	1.000
Үгүй	0.870***	1.462***
МБСБ/ИДС-д суралцаж байх хугацаанд хийж үзсэн ажлын тоо		
Төгсөлтөөс хойш одоогийн ажилд ортол хүлээсэн хугацаа /сар/	1.034*	1.173***
Мэргэжлийн анхны ажлаа олох хүртлээ/өнөөг хүртэл ажил хайж үзсэн эсэх	1.057***	1.069***
Тийм	1.000	1.000
Үгүй	0.876**	0.543***

ЗАГВАР 1-А: Ажил эрхэлж буй төгсөгчдийн эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн

Нөлөөлөгч хүчин зүйлс	Эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэх харьцангуй магадлал (Odds ratio)	
	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч
МБСБ/ИДС төгсөхөөс өмнө сонгон тодорхойлсон ажлын зорилго байсан эсэх		
Тийм	1.000	1.000
Үгүй	1.161***	1.087
ОДООГИЙН АЖЛЫН БАЙРНЫ ОНЦЛОГ		
Одоогийн ажлын байрны эдийн засгийн үйл ажиллагааны салбар		
Боловсрол	1.000***	1.000***
ХАА, ойн аж ахуй, загас, ан агнуур	0.514	0.451*
Уул уурхай, олборлолт	2.633***	0.394***
Боловсруулах үйлдвэрлэл	7.752***	0.952
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.039	0.195***
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	7.511***	1.498
Барилга	2.812***	0.147***
Бөөний/жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	6.539***	1.280
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	11.128***	0.626
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	5.794***	0.360***
Мэдээлэл, холбоо	2.506***	0.365**
Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	1.438**	0.560
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2.531***	n/a
Мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл ажиллагаа	0.915	1.642
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5.243***	1.373
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.751***	0.415***
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамж	0.959	0.598
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.668***	0.147***
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5.109***	0.317***
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.058***	n/a
Ажил олгогчийн хэлбэр		
Дотоодын хөрөнгө оруулалттай компани	1.000***	1.000***
Гадаадын хөрөнгө оруулалттай/дотоод гадаад хамтарсан компани	1.461***	1.102
Төрийн захиргааны/үйлчилгээний байгууллага	0.622***	0.558***
Төрийн өмчит үйлдвэр	0.559***	0.367***
ТББ/тусгай сан/нийгэмлэг/ОУБ/бусад	8.776***	0.527*
Одоогийн ажлын байрны хэлбэр		
Цалин хөлстэй, байнгын ажилтан	1.000***	1.000**
Цалин хөлстэй, улирлын/түр ажилтан	0.750**	1.544***
Цалин хөлсгүй, ажил олгогч/ хувиараа бизнес эрхлэгч/ өрхийн бизнес эрхлэгч	1.807***	0.951
Одоогийн ажилд ажилласан хугацаа /сараар/	1.054***	1.062***
Сарын дундаж цалин/орлого	1.000***	1.000*
СУРАЛЦАХ ХУГАЦААНЫ АМЖИЛТ, СУРСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫН АЧ ТУСЫГ ҮНЭЛЭХ БАЙДАЛ		
ИДС/МБСБ төгссөн голч дүн	0.994*	0.981***
Сурах хугацаанд олж авсан мэдлэг одоогийн ажилд нь тус болдог эсэх		
Үгүй	1.000	1.000
Тийм	0.339***	0.085***

ЗАГВАР 1-А: Ажил эрхэлж буй төгсөгчдийн эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн

Нөлөөлөгч хүчин зүйлс	Эзэмшсэн мэргэжилтэй тохирохгүй ажил эрхлэх харьцангуй магадлал (Odds ratio)	
	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч
Сурах хугацаанд олж авсан ур чадвар одоогийн ажилд нь тус болдог эсэх		
Үгүй	1.000	1.000
Тийм	0.236***	0.428***
Эзэмшсэн боловсрол, ур чадваруудын аль нэг нь эсвэл хоёулаа ажлын байрны шаардлагаас доогуур эсэх		
Үгүй	1.000	1.000
Тийм	0.757***	0.813**
Загварын -2log likelihood утга	16082.705***	7319.381***
Загварын тайлбарлах чадвар	79.2%	81.3%
Ажил эрхэлж байгаа төгсөгчдийн тоо	18913	8478

Odds ratio утгуудын ард: *** бол 99.9-аас багагүй хувийн итгэх түвшинд ($p \leq 0.001$), ** бол 99.0 хувиас багагүй итгэх түвшинд ($p \leq 0.01$), * бол 95.0 хувиас багагүй итгэх түвшинд ($p \leq 0.05$) тайлбарлагдана. n/a-ИДС/МБСБ төгсөгчдөөс тухайн асуултын хүрээнд мэдээлэл цуглуулаагүй

Монгол улсад дээд болон мэргэжлийн боловсрол олгодог байгууллагуудын ихэнх нь нийслэл хотод төвлөрсөн байдаг ба орон нутгуудын сургуулиудад багш, боловсон хүчний болон техник технологийн гээд сургалтын орчны олон асуудал хөгжлийн хувьд хоцрогдолтой гэж үзэх хандлага нийтийн дунд байдаг. Тэгвэл, энэ удаагийн судалгаагаар төгсөгчдийн хаана суралцаж төгссөн эсэх нь тэдний мэргэжлийн дагуу ажил олж чадах байдалд статистик ач холбогдол бүхий нөлөөгүй гарчээ. Харин төрийн өмчийн ИДС төгсөгчидтэй харьцуулахад, хувийн өмчийн ИДС төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил хийх OR магадлал 1.226 дахин өндөр ($p \leq 0.001$) байна.

Мэргэжил сонголтоо хэрхэн хийсэн, мөн эзэмшсэн мэргэжилдээ сэтгэл хангалуун байдаг эсэх нь төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд гарах үедээ мэргэжлийн дагуу ажиллах байдалд чухал нөлөөтэй байна. Тухайлбал, өөрийн хүсэл сонирхлын дагуу мэргэжлээ сонгосон төгсөгчидтэй харьцуулахад эцэг эх, багш болон бусад хүмүүсийн саналыг дагаж мэргэжил сонголтоо хийсэн ИДС төгсөгчдийн мэргэжлээсээ өөр ажил хийх OR магадлал 2.086 дахин өндөр ($p \leq 0.001$), элсэлтийн шалгалтын оноо хүрээгүйн улмаас тааралдсан мэргэжлээ сонгох замаар мэргэжил эзэмшсэн хүмүүсийн OR магадлал 1.821 дахин өндөр ($p \leq 0.001$), мөн тухайн мэргэжил нийгэмд нэр хүндтэй, эсвэл төгссөний дараа ажил олгоход

хялбар, уг мэргэжлээр ажиллахад хөгжих боломжтой зэрэг мэргэжлийн ирээдүйн “үр өгөөж, боломж”-ийг харгалзан мэргэжлээ сонгосон төгсөгчдийн OR магадлал 1.286 дахин өндөр ($p \leq 0.001$) байна.

Харин МБСБ төгсөгчдийн хувьд өөрийн хүсэл сонирхлын дагуу мэргэжил сонгохоос илүүтэй тухайн мэргэжлийн ирээдүйн үр өгөөж, боломжийг харгалзан мэргэжил сонгосон тохиолдолд хөдөлмөрийн зах зээлд гарах үедээ мэргэжлийн бус ажил хийхгүй байх боломж илүүтэй байгаа ($OR = 0.740^{***}$) нь харагдлаа.

ИДС болон МБСБ төгсөгчдийн аль алины хувьд мэргэжилдээ сэтгэл хангалуун байдал буурах тусам төгсөөд мэргэжлийн дагуу ажиллахгүй байх магадлал нэмэгдэж байна. Жишээлбэл, мэргэжилдээ “маш сэтгэл хангалуун” төгсөгчидтэй харьцуулахад сэтгэл ханамж доогуур болон ханамжгүй төгсөгчдийн мэргэжлийн дагуу ажиллахгүй байх OR магадлал ИДС төгсөгчдийн дунд 2.5-6.3 дахин өндөр, МБСБ төгсөгчдийн дунд 1.5-21.0 дахин өндөр ($p \leq 0.001$) гэсэн үр дүн гарчээ. Дээрх үр дүнгүүдээс дүгнэхэд, төгсөгчдийн суралцах үедээ зарцуулсан цаг хугацаа, эдийн засгийн өртгийг хөдөлмөрийн зах зээлд аль болох бүрэн ашиглахын тулд залуучуудын мэргэжил сонголтод ихээхэн анхаарал тавих, мэргэжлээ зөв сонгоход нь туслах шаардлагатай нь харагдаж байна.

Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл тэднийг ажлын байранд гараад мэргэжлийн дагуух ажлаа хийхэд нь чухал нөлөөтэй гэсэн үр дүн шинжилгээгээр гарчээ. ИДС төгсөгчдийн хувьд багш, боловсрол судлалын чиглэлээр мэргэжил эзэмшсэн төгсөгчидтэй харьцуулахад биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ (3.852***), байгаль хамгаалал (3.762***), нийгэм, эдийн засаг (2.897***), хууль, эрх зүй (2.364***), физик, хими, геологи, газар зүй (2.062***) зэрэг чиглэлийн мэргэжилтэй ажиллагчдын мэргэжилтэйгээ тохирохгүй ажил хийх ОР магадлал 1.247-3.852 дахин өндөр байна. Харин эсрэгээрээ, урлаг (0.613*), хүмүүнлэгийн ухаан (0.707**), мал эмнэлгийн (0.528**) чиглэлээр төгсөгчдийн мэргэжлээсээ өөр чиглэлийн ажил хийх ОР магадлал 30-47 пунктээр бага байгаа нь эдгээр мэргэжлүүдээр Монгол улс дахь ажиллах хүчний нийлүүлэлт харьцангуй илүүдэлгүй байгааг илтгэж байна.

МБСБ төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээр нь авч үзвэл, боловсрол, эрүүл мэндээс бусад чиглэлийн мэргэжлийн хувьд мэргэжлээс гадуурх ажил эрхлэлтэд нь тэдний эзэмшсэн мэргэжлийн чиглэл статистик ач холбогдол бүхий нөлөөгүй гарсан байна. Харин МБСБ-ыг боловсролын чиглэлээр төгсөгчидтэй харьцуулахад эрүүл мэндийн чиглэлээр төгссөн хүмүүсийн дунд мэргэжлээсээ өөр ажил хийх ОР магадлал бараг 85 хувиар доогуур байна ($p \leq 0.001$).

Ийнхүү энэ удаагийн судалгаагаар ИДС-ийн нэлээд олон чиглэлийн мэргэжлээр төгсөгчдийн дунд мэргэжлээсээ өөр чиглэлээр ажил эрхлэх магадлал өндөр гарсан нь дараах шалтгаануудтай байж болох юм. Үүнд: 1) тухайн мэргэжлийн эрэлт зах зээлд хангагдсан буюу төгсөгчдийг мэргэжлээр нь шингээх ажлын байрууд хангалтгүй байгаа; 2) ажил хайж буй төгсөгчийн мэргэжил эзэмшсэн байдал, ур чадвар нь ажил олгогчид гологддог; 3) зарим ажил мэргэжлүүдийн хөдөлмөрийн хөлсний үнэлэмж, ажиллах нөхцөл байдлын харьцангуй таатай биш нөхцөл нь төгсөгчдийг илүү нөхцөл сайтай боловч мэргэжлийн дагуу биш ажил хийхэд хүргэдэг; 4) аргагүйн эрхэнд, сонирхоогүй мэргэжлээрээ суралцсан залуучууд төгсөөд мэргэжлээрээ ажиллахгүй байх зэрэг байж болох юм. Эдгээр таамаглалыг шалгахад олон нэмэлт судалгаа, мэдээллүүд шаардлагатай ба одоогоор, ХНХСИ-ээс бүх төрлийн ажил олгогчдын

төлөөллийг хамруулан үндэсний хэмжээний түүвэрлэлттэйгээр хийсэн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-2017-оор дээрх таамаглалуудтай холбоотой зарим мэдээллийг гаргажээ. Уг судалгаагаар, ажил олгогчдод шинээр ажилтан авч ажиллуулахад хамгийн их тохиолддог бэрхшээлүүдэд ажил хайгчийн ажлын туршлагагүй байдал (31.5 хувь), боловсрол, мэргэжлийн түвшин нь ажлын байрны шаардлагад нийцдэггүй (23.5 хувь), ажил хайгч ажлын байрны орчин нөхцөл, цалин хөлс голдог (13.2 хувь) зэрэг орж байна. Эндээс дүгнэхэд, төгсөгчдийн мэргэжлийн дагуу ажиллахгүй байдалд зөвхөн хувь хүний хүчин зүйлс төдийгүй боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллага, ажил олгогчид, төр зэрэг олон оролцогч талуудын ажлын үр дүн, чанар нөлөөлж байна.

ИДС төгсөгчдийн хувьд давхар/хос мэргэжилтэй байх нь хос мэргэжилгүй хүмүүсийг бодвол мэргэжлийн дагуу ажил хийхэд давуу тал болж байна. Тухайлбал, хос/давхар мэргэжилтэй ИДС төгсөгчдийн мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллах ОР магадлалыг 1.000 гэж үзвэл хос мэргэжилгүй хүмүүсийн ижил магадлал түүнээс 1.802 дахин өндөр ($p \leq 0.001$) байна. Харин МБСБ төгсөгчдийн хувьд давхар/хос мэргэжил эзэмшихгүй байсан ч мэргэжлээс өөр төрлийн ажил хийх магадлал давхар мэргэжилтэй төгсөгчдийнхөөс бага ($OR = 0.860^*$) байна. Энэ нь мэргэжлийн дагуух ажил олж чадахгүй байгаа МБСБ төгсөгчид дахин өөр мэргэжлээр суралцах хандлагатай болохыг харуулж байж болох юм.

Төгсөгчдийн ажил хөдөлмөрт бэлтгэх чиглэлээр өөрсдийнх нь гаргасан хичээл зүтгэл, оролдлогууд тэднийг мэргэжилтэйгээ тохирох ажил хийх эсэхэд хэрхэн нөлөөлж буйг авч үзье.

Сургуульд элсэн орсноос хойш ажил хөдөлмөртэй холбоотой сургалт/хөтөлбөр/арга хэмжээнд нэмэлтээр хамрагдаж байсан төгсөгчидтэй харьцуулахад хамрагдаж байгаагүй МБСБ төгсөгчдийн мэргэжлийн дагуу ажиллахгүй байх ОР магадлал 1.462 дахин өндөр байна. Харин ИДС төгсөгчдийн хувьд богино хугацааны нэмэлт сургалтад хамрагдаагүй байсан ч тийм сургалтад хамрагдаж байсан хүмүүсээс илүүтэйгээр мэргэжлийн дагуух ажлаа олж хийж чадаж

байна (мэргэжлээс өөр ажил эрхлэх OR магадлал 0.870***). Ерөнхийдөө, МБСБ-ын сургалт ИДС-ийг бодвол харьцангуй богино хугацаанд үргэлжилдэг тул суралцах хугацаанд амжиж мэдэж чадаагүй зүйлсээ МБСБ төгсөгчид нэмэлтээр өөр сургалтад хамрагдах замаар мэдэж аван, ажилд ордог байж болох юм.

ИДС болон МБСБ төгсөгчдийн хувьд суралцаж байх хугацаандаа ажил хийж байсан туршлага буюу хийж үзсэн ажлын тоо нь мэргэжлийн дагуу ажиллахгүй байхад нөлөөтэй үр дүн гарсан байна. Жишээ нь, суралцаж байх хугацаандаа олон төрлийн ажил хийж үзсэн байх тусам төгсөгчдийн мэргэжлийн бус чиглэлээр ажил сонгож эрхлэх байдал нэмэгдэж (хийж үзсэн ажлын тоо 1-ээр нэмэгдэхэд мэргэжлийн бус ажил эрхлэх OR магадлал ИДС төгсөгчдийн хувьд 1.034* дахин, МБСБ төгсөгчдийн хувьд 1.173 дахин***) байна. Энэ нь төрөл бүрийн ажил хийж үзсэн төгсөгчид олон боломжит ажил дотроос аль цалин өндөр, эсвэл бусад талаараа давуу тал илүүтэй олгож байгаа, эсвэл олдцотой байгаа ажлын байруудыг мэргэжлийн дагуу ажлын байраасаа илүүд үзэн сонгодог болохыг харуулж байгаа болов уу.

Судалгаагаар өөр нэг сонирхолтой үр дүн гарсан нь төгсөгчид сургуулиа төгссөнөөс хойш ажилд ортол удаан хүлээх тусам мэргэжлээсээ өөр чиглэлийн ажилд орох магадлал нэмэгдэж байна. Тодруулбал, төгссөнөөс хойш ажилд ортлоо хүлээх хугацаа 1 сараар нэмэгдэх тусам аль олдсон юм уу илүү нөхцөл сайтай ажлуудыг сонгон мэргэжлийн бус чиглэлэр ажиллах OR магадлал ИДС төгсөгчдийн хувьд 1.057 дахин, МБСБ төгсөгчдийн хувьд 1.069 дахин нэмэгдэж байна ($p < 0.001$). Мөн мэргэжлийн дагуу ажилд орох үүднээс мэргэжлийн ажлаа хайж, оролдлого хийж байсан төгсөгчид ($OR = 1.000$)-тэй харьцуулахад мэргэжлийн ажлаа удаан хайгаагүй төгсөгчдийн хувьд мэргэжлийн бус ажил хийх байдал (ИДС төгсөгчдийн хувьд $OR = 0.876^{***}$, МБСБ төгсөгчдийн хувьд $OR = 0.543^{***}$) нь бага байна. Энэ нь төгсөнгүүт удахгүйгээр ажилтай болж чадсан төгсөгчид ихэвчлэн мэргэжлийн чиглэлийн ажлын байруудад ажиллаж, харин ажил хүлээсэн, хайсан төгсөгчдөд ихэвчлэн мэргэжлээс нь өөр чиглэлийн ажлын байрууд үлдэх боломжоор тайлбарлагдаж болох юм.

Дээрх үр дүнгүүдээс гадна, ИДС болон МБСБ төгсөхөөсөө өмнө өөртөө тодорхой ажлын зорилго сонгон тодорхойлсон хүмүүстэй харьцуулахад тодорхой зорилгогүй байсан хүмүүсийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил хийх OR магадлал 1.087-1.161 дахин өндөр байна. Өөрөөр хэлбэл ажлын талаар эртнээс тодорхой зорилго дэвшүүлж байгаагүй хүмүүс мэргэжил болон түүнийг олж авахад зарцуулсан үнэ цэнээ харгалзахгүй аль боломжит ажлын байр руу очих хандлагатай байна.

Төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй чиглэлээр ажиллах магадлал эдийн засгийн үйл ажиллагааны ямар салбаруудад илүүтэй ажиглагдаж байгааг авч үзье. Боловсролын салбартай харьцуулбал олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа; хүний эрүүл мэнд ба нийгмийн халамж; мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл ажиллагаа; хөдөө аж ахуй гэсэн салбаруудад ИДС төгсөгчдийн мэргэжлийн дагуу ажиллах харьцангуй магадлал өндөр, харин бусад бүх салбарт мэргэжлээсээ өөр чиглэлийн ажил хийх OR магадлал 1.438-11.128 дахин өндөр байна.

Ялангуяа ИДС төгсөгчдийг мэргэжлийн бус чиглэлээр нь ихээр ажиллуулах магадлалтай эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудыг онцлон дурьдвал, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа (боловсролын салбараас OR нь 11.128 дахин өндөр***), боловсруулах үйлдвэрлэл ($OR = 7.752^{***}$), ус хангамж бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент ($OR = 7.511^{***}$), бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ ($OR = 6.539^{***}$), зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ ($OR = 5.794^{***}$), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа ($OR = 5.243^{***}$) зэрэг салбарууд орж байна.

Харин МБСБ төгсөгчдийн хувьд дээрх үзүүлэлтийг авч үзвэл, ихээхэн өөр дүр зураг харагдаж байна. Боловсролын салбарт ажил эрхэлж буй МБСБ төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх OR магадлалыг 1.000 гэж үзвэл, бусад бүх салбарт ажиллаж буй төгсөгчдийн мэргэжлийн бус ажил хийх харьцангуй магадлал доогуур буюу 0.147-0.415 хооронд байна. Ялангуяа урлаг, үзвэр, тоглоом наадам ($OR = 0.147^{***}$), барилга ($OR = 0.147^{***}$), цахилгаан, хий, уур,

агааржуулалт ($OR=0.195^{***}$), үйлчилгээний бусад үйл ажиллагаа ($OR=0.317^{***}$), зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ ($OR=0.360^{***}$), мэдээлэл холбоо ($OR=0.365^{**}$) зэрэг салбаруудад ажиллаж буй МБСБ төгсөгчдийн мэргэжлийнхээ дагуу ажиллах байдал боловсролын салбарт ажиллагсдынхаас өндөр байна.

Эдгээр нь нэг талаас ажлын байрны өсөлт Монгол улсын эдийн засгийн хөгжлийн салбаруудад харилцан жигд биш, цөөн салбарт төвлөрсөн байгааг; нөгөө талаас эдийн засгийн үйл ажиллагааны ихэнх салбаруудын ажиллах хүчний эрэлт зах зээлийн хууль ёсоороо хангагдаж чадахгүй; мөн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх боловсролын салбарын бодлого болон хөдөлмөрийн зах зээлийн боломж, эрэлтүүдийг харьцуулан судалж, тэдний нийцлийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээнүүд дутагдалтай байгааг харуулж байгаа болов уу.

Төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх байдал ажил олгогчдын төрлөөр багагүй ялгаатай байна. Тухайлбал, дотоодын хөрөнгө оруулалттай компанид ажиллаж буй төгсөгчидтэй харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалттай/гадаад дотоод хамтарсан компанид ажиллаж буй ИДС төгсөгчдийн мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллах OR магадлал 1.46 дахин ($p<0.001$), МБСБ төгсөгчдийн OR магадлал 1.1 дахин өндөр байна. Харин төрийн захиргааны/үйлчилгээний байгууллага болон төрийн өмчит үйлдвэрийн газруудад ажиллаж буй аль ч сургууль төгссөн төгсөгчдийн дунд мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллах хандлага эрс бага байгаа ($OR=0.367-0.662$) нь сайшаалтай.

Одоогийн ажлын байрны хэлбэрээр нь авч үзвэл, цалин хөлстэй байнгын ажлын байртай харьцуулахад цалин хөлсгүй ажил олгогч/хувиараа бизнес эрхлэх ажилд байгаа ИДС төгсөгчид 1.807 дахин өндөр магадлалтайгаар мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллахаар байна. Мөн цалин хөлстэй улирлын/түр ажилтны ажлын байранд байгаа ИДС төгсөгчдийн мэргэжлийн бус ажил хийх магадлал бага ($OR=0.75^{**}$), харин МБСБ төгсөгчдийн ижил магадлал өндөр ($OR=1.544^{***}$) байна. Өөрөөр хэлбэл, ажил эрхэлж байгаа ИДС төгсөгчдийн хувьд түр

ажлын байрууд дээр мэргэжлийн дагуух ажлаа хийх магадлал илүү өндөр байхад, МБСБ төгсөгчдийн хувьд байнгын ажлын байрууд дээр илүүтэйгээр мэргэжлийн ажлаа хийх магадлалтай байна. Эдгээр нь МУ дахь ИДС болон МБСБ-уудын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлого ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлтүүд хоорондын уялдаатай төлөвлөлт дутагдаж байгааг мөн харуулж байна.

Ажлын байрандаа эзэмшсэн мэргэжлээсээ өөр чиглэлээр нэгэнт ажиллаад эхэлсэн хүмүүс ажилласан хугацаа болон цалин нь нэмэгдэхийн хэрээр уг ажлаа солихгүй, ажилласаар байх хандлагатай байна ($p<0.001$).

Төгсөгчдийн суралцах хугацааны сурлагын амжилт, олж авсан мэдлэг, чадвар нь төгссөний дараа мэргэжлийн дагуу ажиллах байдалд хэрхэн нөлөөлж буйг авч үзвэл, ИДС болон МБСБ төгсөгчдийн сургууль төгссөн голч оноо/дүн нэгжээр нэмэгдэх тусам мэргэжлээсээ өөр чиглэлийн ажилд ажиллах магадлал багасаж байна (ИДС төгсөгчдийн хувьд $OR=0.994^*$, МБСБ төгсөгчдийн хувьд $OR=0.981^{***}$). Өөрөөр хэлбэл, сургуулиа илүү амжилттай дүнтэй төгссөн төгсөгчдөд мэргэжлийн дагуух ажлаа олж хийх боломж илүү байна.

Суралцах хугацаанд олж авсан мэдлэг болон ур чадвар нь одоогийн ажилд тус болдог эсэхээр авч үзэхэд тус болдог гэж үзэж буй төгсөгчдийн мэргэжлийн бус ажил хийх OR магадлал мэдлэг, ур чадвар хэрэг болохгүй байгаа гэсэн хүмүүсийнхээс 57.2-91.5 пунктээр доогуур байна.

Түүнчлэн сургуульд эзэмшсэн өөрийн мэдлэг, ур чадвараа ажил олгогчийн шаардлагад хүрдэггүй гэж өөрийгөө үнэлж буй төгсөгчдийн дунд мэргэжлийн бус ажил хийх OR магадлал ажил олгогчийн шаардлагад тэнцдэг гэж өөрийгөө үнэлсэн хүмүүсийнхээс 18.7-24.3 пунктээр бага (ИДС төгсөгчдийн хувьд $OR=0.757^*$, МБСБ төгсөгчдийн хувьд $OR=0.813^{***}$) байна. Энэ нь нэгэнт төгсөгчид өөрийн мэдлэг, ур чадварыг ажлын байрныхаа тавигдах шаардлага, түвшинд тохирохгүй гэдгийг мэдэж байгаа бол тухайн ажлыг хийхгүй байх магадлал байна гэсэн үг юм.

5. ДҮГНЭЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү шинжилгээгээр МУ дахь ИДС болон МБСБ төгсөгчдийн хэр хэсэг нь хөдөлмөрийн зах зээлд ажилтай болж чадаж байгаа эсэхийг хөндөхөөс илүүтэй “ажил эрхэлж байгаа” төгсөгчдийн дундах тулгамдсан асуудлуудын нэг болох мэргэжлийн бус чиглэлээр ажиллах байдлыг авч үзлээ. Төгсөгчдийн хувьд төгсөлтөөс хойш хөдөлмөрийн зах зээлд ороход богино хугацаанд ажилтай болох нь чухал хэдий ч тодорхой цаг хугацаа, хөрөнгө, хүч зарцуулан эзэмшсэн мэргэжлийн дагуу ажил эрхэлж чадах эсэх, мэргэжлээ бүрэн ашиглахуйц, өөрийн боловсрол, чадварын түвшинд тохирохуйц ажил эрхлэх нь чанарын талаасаа илүү чухал үзүүлэлт юм. Ялангуяа мэргэжийн дагуух ажлын байр олдохгүй юм уу бусад шалтгаанаар мэргэжлийн бус ажил эрхлэх нь эдийн засгийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх төдийгүй хөдөлмөрийн нөөц бүрэн бусаар ашиглагдаж байгаа нэг хэлбэр гэж

болно.

Энэ удаагийн судалгаагаар, сургууль төгссөнөөс 1 жилийн дараах байдлаар ажилтай болж чадсан ИДС төгсөгчдийн 30.2 хувь, МБСБ төгсөгчдийн 38.8 хувь нь тус тус мэргэжлээсээ өөр чиглэлийн ажил эрхэлж байна.

Мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх магадлалд хувь хүний шинж байдал, мэргэжил эзэмшсэн түүх, байдал; ажил хөдөлмөрт бэлтгэх чиглэлээр гаргасан нэмэлт хүчин зүтгэл; ажиллах эдийн засгийн үйл ажиллагааны салбар; ажлын байр/ажил олгогчдын онцлог; сурсан мэдлэг чадварынх нь ажлын байран дээр хэрэг болох байдал зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөтэй байгаагаас, дараах хүчин зүйлүүд нь бодлогын арга хэрэгсэл байдлаар удирдан залах боломжтой чухал хүчин зүйлүүд гэж үзэж байна. Үүнд:

Төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх ОР магадлалыг өндөр болгож буй зарим хүчин зүйлс	
<p>ИДС төгсөгчдийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - Хувийн өмчийн ИДС төгсөх - Мэргэжил эзэмшүүлэх сургуулиа доогуур үнэлгээ/дүнтэй төгсөх - Дараах чиглэлээр мэргэжил эзэмших (эрэмбэлснээр): Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ; Байгаль хамгаалал; Нийгэм, эдийн засаг; Хууль, эрх зүй; Физик, хими, геологи, газар зүй; Мэдээлэл, сэтгүүл зүй; Биологи; Нийгмийн халамж, хангамж; Бүх төрлийн инженер; ХАА, ой, загасны аж ахуй; Үйлдвэрлэлийн технологи - Мэргэжил сонголтоо өөрийн хүсэл сонирхолд үндэслэн хийхгүй байх (бусдын санал, зөвлөгөөг дагах; элсэлтийн шалгалтын оноо бага тул хүсээгүй мэргэжил сонгох; мэргэжлийн нийгэм дэх нэр хүнд, ажил элбэг олддог байдал, ажил мэргэжлээрээ хөгжих боломжтой зэргийг харгалзан сонгох) - Мэргэжлийнхээ талаар сэтгэл ханамж доогуур байх - Мэргэжил олгох сургуулиа төгссөнөөс хойш ажилд орохгүй удах - Гадаадын хөрөнгө оруулалттай компани, гадаад дотоод хамтарсан хөрөнгө оруулалттай компани, ТББ/тусгай санд ажиллах; - Эдийн засгийн дараах салбаруудад ажиллах (эрэмбэлснээр): Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа; Боловсруулах үйлдвэрлэл; Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа; Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ; Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; гэх мэт 	<p>МБСБ төгсөгчдийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжил эзэмшүүлэх сургуулиа доогуур үнэлгээ/дүнтэй төгсөх - Боловсролын чиглэлээр мэргэжил эзэмших - Төгссөний дараа ажил олоход хялбар, уг мэргэжлээр ажиллахад хөгжих боломжтой зэргийг харгалзахгүйгээр цэвэр өөрийн сонирхолд үндэслэн мэргэжил сонгох - Мэргэжлийнхээ талаар сэтгэл ханамж доогуур байх - Ажил хөдөлмөртэй холбоотой сургалт/хөтөлбөр/ арга хэмжээнд нэмэлтээр хамрагдахгүй байх - Мэргэжил олгох сургуулиа төгссөнөөс хойш ажилд орохгүй удах - Дотоодын хөрөнгө оруулалттай компанид ажиллах - Цалин хөлстэй улирлын/түр ажлын байранд ажиллах - Боловсролын салбарт ажиллах

Эдгээр хүчин зүйлүүдэд үндэслэн цаашид төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллах

байдал хэрхэн өөрчлөгдөх төлөвтэй байгааг дүгнэхийн тулд ХНХЯ, ХНХСИ-ээс жил бүр ажил олгогчдын дунд хийдэг Хөдөлмөрийн

зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-аас зарим холбогдох үр дүнг авч, энэ удаагийн шинжилгээтэй харьцуулж үзье.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-2017 (цаашид Барометрийн судалгаа-2017 гэнэ)-оор, 2017 онд зохих мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс 10.9 мянган ажиллах хүчний хомсдол аж ахуйн нэгж байгууллагуудын хэмжээнд бий болсон бөгөөд бөөний болон жижиглэн худалдаа үйлчилгээний салбар, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбар хамгийн ихээр энэ хомсдолд өртсөн гэсэн байна. Ажил олгогчдын зүгээс хөдөлмөрийн эрэлтээ хангахын тулд ИДС төгсөгчдийг мэргэжлийн бус байсан ч дээрх салбаруудад ихээр авч ажиллуулсан хандлага байсан нь энэ удаагийн төгсөгчдийн судалгааны үр дүнгээр батлагдлаа.

Цаашид буюу 2018 онд хөдөлмөрийн зах зээлийн нийт эрэлт ямар байх, эдийн засгийн салбаруудаар эрэлтүүд ямар байхыг тооцоолсон Барометрийн судалгаа-2017-ийн үр дүнгээс харвал, 2018 онд ажиллах хүчний эрэлтийн хэмжээ 74.6 мянга болж, өнгөрсөн оны судалгааны үеийнхээс 5.5 хувиар өсөх хандлагатай, шинээр бий болох эрэлтүүд дотор мөн л барилгын салбар, бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажиллах хүчний эрэлтүүд (тус тус 18.6 мянга ба 15.2 мянга) бусад салбарынхаас илүү өндөр байх төлөв гарсан байна. Иймд дээрх салбаруудад ажиллах боломжтой мэргэжилтнүүдийг боловсролын салбар түлхүү бэлтгэвэл төгсөгчдийн мэргэжлийн бус ажил эрхлэлтийн түвшин багасах боломжтой гэж харагдаж байна. Гэвч өнөөгийн байдлаар Монгол улс дахь мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх байгууллагууд, ялангуяа ИДС-ууд элсэлтээ голдуу суралцагчдын хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд тулгуурласан байдлаар авч байгаа бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн бодит эрэлт, боломжтой уялдуулан элсэлт авах бодлого, квотоо тодорхойлох, хэрэгжүүлэх байдал хангалтгүй байгаа юм.

Барометрийн судалгаа нь 2018 онд бий болох ажиллах хүчний эрэлтийн 71.5 хувь нь байнгын ажлын байр байх хүлээлттэй байгаа гэжээ. Гэвч энэ удаагийн шинжилгээгээр, ИДС төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах магадлал түр ажлын байрууд дээр хамгийн өндөр, харин МБСБ-ын ижил магадлал

байнгын ажлын байрууд дээр илүү өндөр байсныг холбон үзвэл, мэргэжлийн дагуу ажиллах боломж бололцоо нь зах зээлийн эрэлт талаасаа МБСБ төгсөгчдийн хувьд ИДС төгсөгчдийнхөөс өндөр байж магадгүй гэж харагдаж байна.

Түүнчлэн, Барометрийн судалгаа 2017-оор гаргасан ажиллах хүчний 2018 оны эрэлтийг ажил мэргэжлийн ангиллаар нарийвчлан харвал, хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлттэй байгаа эхний 20 ажил, мэргэжлүүд дотор барилга, үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтан, цэвэрлэгч, угаач үйлчлэгч зэрэг мэргэжил шаардахгүй энгийн ажил мэргэжил; засалчин, шаварчин, худалдагч, оёдолчин, эм найруулагч, тогооч, мужаан, цахилгаанчин зэрэг мэргэжлийн болон техникийн боловсролоор бэлтгэдэг ажил мэргэжил; нягтлан бодогч, барилгын инженер, хийн хоолойн инженер зэрэг дээд боловсролоор бэлтгэдэг ажил мэргэжлүүд эрэмбэлэгдэн орсон байна. Эдгээрийг төгсөгчдийн судалгааны үр дүнтэй холбон үзвэл, мөн л МБСБ төгсөгчдийн хувьд дээрх ажлын байруудыг сонирхон ажил олгогчидтой холбогдож чадвал мэргэжлээрээ ажиллах боломж нь ИДС төгсөгчдийнхөөс өндөр байна.

Иймд, өнөөгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн нөхцөл байдал нь МБСБ төгсөгчдийн мэргэжлийн бус ажил эрхлэлтийн түвшинг бууруулахад илүүтэй эерэг нөлөө үзүүлэх боломжтой, харин ИДС төгсөгчдийн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил эрхлэх хандлагыг бууруулахад төдийлөн дорвитой нөлөө үзүүлэхгүй байх гэж харагдаж байна.

Цаашид төгсөгчдийн мэргэжлээсээ өөр чиглэлээр ажиллах хандлагыг мэргэжлийн дагуу ажилладаг болгон өөрчлөхийн тулд:

- Судлаачид, төлөвлөгчид мэргэжилтэй ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийг тус тусад нь бус, цогцоор нь уялдуулан судлах судалгааны ажлуудыг тогтмол хийж, бодлого төлөвлөлт, үнэлгээнд ашигладаг байх;
- Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх боловсролын салбарын бодлого ба хөдөлмөрийн зах зээлийн бодлогын төлөвлөлтийг хооронд нь уялдаатай хийж, хэрэгжүүлэх;
- Хувь хүмүүсийн мэргэжил сонголтыг

цаашид ажиллахыг хүсч буй чиглэл рүү нь болон эрэлттэй ажлын байртай холбоотой чиглэлүүд рүү хандуулан зөв хийлгэхэд микро, макро бүх оролцогч талууд анхаарал хандуулан, арга хэмжээ авах нь зүйтэй болов уу.

Эцэст нь дүгнэхэд, хэдийгээр хүний хөгжлийн онолын үүднээс харвал хувь хүмүүст байгаа авъяас, нөөц, боломж, чадавхид тохирсон ажлын байрууд улс оронд ихээр бий болох нь зүйтэй хэдий ч Монгол улсын өнөөгийн хөгжлийн түвшинд ихэвчлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтдээ нийцсэн мэргэжилтнүүдийг түлхүү бэлтгэх бодлого буруудахгүй болов уу. Яваандаа эдийн засгийн олон салбаруудыг жигд хөгжүүлэх замаар салбар бүрт ажиллах хүчний эрэлтийг нэмэгдүүлснээр дээд боловсролын салбараас төгсөж буй “илүүдэлтэй мэргэжилтэн” үзэгдлийн алдаатай байдал ч засагдах боломжтой гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

ХНХЯ, ХНХСИ, 2017. *Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2017 (2015-2016 оны төгсөгчид)* судалгааны тайлан, Улаанбаатар

ХНХЯ, ХНХСИ, 2017. *Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, 2017* (судалгааны тайлан), Улаанбаатар

ХНХЯ, ХНХСИ, 2017. *Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2017 (2015-2016 оны төгсөгчид)* судалгааны мэдээллийн бааз

Karen A. Grace-Martin, 2016. *Logistic Regression Analysis: Understanding Odds and Probability* (available at <https://www.theanalysisfactor.com/explaining-logistic-regression/>)

Stephen A. Sweet, Karen A. Grace-Martin, 2012. *Data analysis with SPSS: First course in Applied Statistics* (4th edition)

Хавсралт

Хавсралт 1. Ложистик регрессийн шинжилгээнд ашигласан нөлөөлөгч хувьсагчдын тайлбар			
№	Хувьсагчийн нэр	Хувьсагчийн утга	Тайлбар
1	Хүйс	1= эрэгтэй 2= эмэгтэй	-
2	Нас		Задгай тоо бүхий харьцааны түвшний хэмжигдэхүүн
3	Гэрлэлтийн байдал	1 = ганц бие 2 = Гэр бүлтэй	1 = Огт гэрлээгүй/салсан/тусгаарласан 2 = Гэрлэсэн/хамтран амьдардаг
4	Амьдарч буй бүс нутаг	1 = Нийслэл 2 = Баруун 3 = Хангайн 4 = Төвийн 5 = Зүүн	1 = Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай 2 =Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Орхон, Булган, Өвөрхангай 3 = Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Дорноговь 4 = Хэнтий, Сүхбаатар, Дорнод 5 = Улаанбаатар
5	Өрхийн нэг хүнд ногдох орлого	1000₮-өөр хэмжигдэнэ	Өрхийн сарын нийт орлогыг өрхийн ам бүлийн тоонд харьцуулсан харьцаа
6	Төрөлжсөн сургалттай ЕБС төгссөн эсэх	1=үгүй 2=тийм	
7	Төгссөн ИДС/МБСБ-ын өмчийн хэлбэр	1 = төрийн өмчийн 2 =хувийн өмчийн/гадаадын салбар сургууль	
8	Төгссөн ИДС/МБСБ-ын байршил	1=Улаанбаатар 2=Бусад аймаг	
9	Эзэмшсэн мэргэжлийн чиглэл		Асуулга дахь 1.35, 1.36 асуултуудын ангиллаар

Хавсралт 1. Ложистик регрессийн шинжилгээнд ашигласан нөлөөлөгч хувьсагчдын тайлбар			
№	Хувьсагчийн нэр	Хувьсагчийн утга	Тайлбар
10	Эзэмшсэн мэргэжлээ сонгосон шалтгаан	1=өөрийн хүсэл сонирхлоор 2=бусад хүмүүсийн саналыг дагаж 3=тухайн мэргэжлийн ирээдүйд олгох боломжийг харгалзан 4=өөр сонголтгүй байсан тул	1=өөрийн хүсэл сонирхлоо харгалзан үзсэн 2=эцэг эх, багш санал боогосон; найз нөхөд, ахлах ангийн ах эгчийн санал; 3=төгссөний дараа мэргэжлээр ажил олдох боломжтой гэж үзсэн; ажил мэргэжлээрээ хөгжих боломжтой; мэргэжлийн үнэлэмж нэр хүнд/ нийгэмд нэр хүндтэй хүлээн зөвшөөрөгдсөн учраас 4=элсэлтийн босго оноо, суурь боловсролын дүн сургуулийн шаардлагад таарсан
11	Мэргэжилдээ сэтгэл хангалуун байдал	1=маш хангалуун 2=хангалуун 3=хангалуун бус 4=огт хангалуун бус	
12	Давхар/хос мэргэжил эзэмшсэн эсэх	1=тийм 2=үгүй	
13	ИДС/МБСБ-д орсноос хойш өнөөг хүртэл ажил хөдөлмөртэй холбоотой сургалт/ хөтөлбөр/арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх	1=тийм 2=үгүй	
14	МБСБ/ИДС-д суралцах хугацаанд хийж үзсэн ажлын тоо		Сургуульд суралцах хугацаандаа ажил хийж байгаагүй хүмүүсийн хувьд уг асуултыг хариултыг "0"-ээр авсан
15	Мэргэжлийн анхны ажлаа олох хүртлээ/өнөөг хүртэл ажил хайж үзсэн эсэх	1=тийм 2=үгүй	
16	МБСБ/ИДС төгсөхөөс өмнө сонгон тодорхойлсон ажлын зорилго байсан эсэх	1=тийм 2=үгүй	
17	Төгссөнөөс хойш одоогийн ажилд ортлоо хүлээсэн хугацаа		Сараар хэмжигдэнэ
18	Ажлын байрны эдийн засгийн үйл ажиллагааны салбар		Асуулга дахь 6.3 асуултын ангиллаар
19	Ажил олгогчийн хэлбэр	1=дотоодын хөрөнгө оруулалттай компани 2=гадаадын хөрөнгө оруулалттай/дотоод гадаад хамтарсан компани 3=төрийн захиргааны үйлчилгээний байгууллага 4=хувиараа хөдөлмөр эрхлэгч 5=төрийн өмчит үйлдвэр 6=ТББ/тусгай сан/нийгэмлэг /ОУБ/бусад	

Хавсралт 1. Ложистик регрессийн шинжилгээнд ашигласан нөлөөлөгч хувьсагчдын тайлбар			
№	Хувьсагчийн нэр	Хувьсагчийн утга	Тайлбар
20	Ажлын байрны хэлбэр	1=цалин хөлстэй байнгын ажилтан 2=цалин хөлстэй улирлын/түр ажилтан 3=цалин хөлсгүй ажил олгогч/хувиараа бизнес эрхлэгч / өрхийн бизнес	
21	Одоогийн ажилд ажилласан хугацаа		Сараар хэмжигдэнэ
22	Сарын дундаж цалин/орлого		Төгрөгөөр хэмжигдэх задгай тоо
23	Одоогийн эрхэлж буй ажил эзэмшсэн мэргэжилтэй нь хэр тохирдог эсэх	1=огт тохиромжгүй 2=тийм ч тохиромжтой биш 3=тохиромжтой 4=маш тохиромжтой	
24	Эзэмшсэн мэргэжил нь одоогийн ажил мэргэжилтэй ижил эсэх	1=эзэмшсэнээс дээгүүр түвшний ажил мэргэжлээр ажиллаж байгаа 2= ижил түвшний ажил мэргэжлээр ажиллаж байгаа 3=доогуур түвшний ажил мэргэжлээр ажиллаж байгаа	ҮАМАТ кодоор кодлогдсон эзэмшсэн мэргэжлийн ангилал болон одоогийн эрхэлж буй ажил мэргэжлийн ангиллуудыг харьцуулж гаргасан
25	ИДС/МБСБ төгссөн голч оноо		60-100 хүртэл оноогоор хэмжигдэх задгай тоо
26	Сурах хугацаанд олж авсан мэдлэг одоогийн ажилд нь тус болдог эсэх	1=үгүй 2=тийм	
27	Сурах хугацаанд олж авсан ур чадвар одоогийн ажилд нь тус болдог эсэх	1=үгүй 2=тийм	
28	Суралцах үед эзэмшсэн боловсрол, ур чадварын аль нэг, эсвэл хоёулаа ажил олгогчийн шаардлагад хүрдэггүй эсэх	1=үгүй 2=тийм	